



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/640

Ховд

Цэвэр, бохирын шугам сүлжээнд айл өрхийг холбох дэмжлэг
/Жаргалант сум, Тахилт баг/-н ажлыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Калдера тубо” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Цэвэр, бохирын шугам сүлжээнд айл өрхийг холбох дэмжлэг /Жаргалант сум, Тахилт баг/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Ажлын хэсгийн
ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч
- Гишүүд: Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын барилгын
техникийн хяналтын улсын байцаагч
- Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Н.Ганбат - “Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газрын дарга
- М.Нансалмаа - “Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын
албаны мэргэжилтэн
- Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжилзүйн хэлтсийн салбар
сан хариуцсан мэргэжилтэн

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга
Ц.Өлзийбат - "Калдера тубо" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. "Калдера тубо" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН